



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2014 оны 11 сарын 07 өдөр

Дугаар A-177

Улаанбаатар хот

┌ Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд ┐
хэрэгжүүлэх стратегийн баримт бичгийг
батлах тухай


Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги”-ийг хавсралтаар баталсугай.

2. Уг баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, хэрэгжилтийн биелэлтийг жил бүрийн дөрөвдүгээр улирлын эцэст Монголбанкны Захирлуудын зөвлөлд тайлагнаж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганбат)-т даалгасугай.

3. Энэ баримт бичгийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДУНД
ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

УХИ0014

А. Хураангуй дүгнэлт:

Монголбанк нь банкуудад хийх хяналт шалгалтыг Төв банкны тухай хуульд заасны дагуу үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл байдлаар хэрэгжүүлдэг бөгөөд үр нөлөөтэй, оновчтой хяналт шалгалтын аргачлалыг бүрдүүлснээр банкны салбарын тогтвортой байдлыг хангах, улмаар макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

Оновчтой, үр нөлөө бүхий хяналт шалгалтын аргачлал, ялангуяа мөчлөг сөрсөн, эрсдэлд суурилсан зохицуулалтыг нэвтрүүлэх асуудалд дэлхийн улс орнууд ихээхэн ач холбогдол өгөх болсон. Учир нь сүүлд үүссэн дэлхийн санхүүгийн хямралаар бодит эдийн засаг болон санхүүгийн салбарт бий болсон аливаа өөрчлөлт нь хоорондоо эерэг эргэх холбоо буюу мөчлөг дагасан хамаарлыг бий болгож, аль нэг салбарт үүссэн хямрал нь бусад салбарт ихээхэн хэмжээний алдагдал учруулж байгаа нь бодит байдал дээр баталгаажсан.

Тиймээс цаашдын хяналт шалгалтын үйл ажиллагааг мөчлөг сөрж, ирээдүйд чиглэсэн шинж чанартай болгоход чиглүүлж, шаардлагатай арга хэмжээг авснаар ирээдүйд учирч болзошгүй аливаа цочролоос урьдчилан сэргийлэх, хямрал бодитоор үүсэхэд үр дагаврын далайцыг бууруулах боломж бүрдэх юм.

Түүнчлэн Монголбанкинд Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад зэрэглэл тогтоогч олон улсын байгууллагуудаас банкны салбарт хийх хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө бүхий дунд хугацааны стратегийг боловсруулж, мөрдөх шаардлагыг тогтмол тавьсаар байгаа бөгөөд сүүлд хийгдсэн (2011 онд) Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөрөөр банкны хяналт шалгалтын дунд хугацааны стратегид дараах зүйлүүдийг багтаахыг зөвлөсөн. Үүнд:

1. Одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах;
2. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх бодлого, аргачлалыг боловсронгуй болгох;
3. Шаардлагатай заавар журам, хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах;
4. Хянан шалгагчдын ур чадварыг дээшлүүлэх;
5. Дотоод болон гадаад хянан шалгагч нартай хамтран ажиллах;
6. Санхүүгийн зах зээлд оролцогчид, сонирхлын бүлгүүдтэй харилцах тогтолцоог сайжруулах;
7. Техник туслалцааг оновчтойгоор хэрэгжүүлэх.

Иймд 2014-2019 оныг хамрах энэхүү стратегийн баримт бичгийг банкны салбарт Монголбанкнаас хийгдэх зохицуулалтын орчинд түгээмэл тохиолдож буй өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хяналт шалгалтын талаарх тэргүүний туршлага, шалгарсан арга, техникийг Монголын банкны салбарын онцлогт тохируулан нэвтрүүлэх зорилготойгоор боловсрууллаа.

В. Дунд хугацааны стратегийн хүрээнд баримтлах бодлогын хураангуй (2014-2019 онуудад)

Банкны хяналт шалгалтын дунд хугацааны стратегид Монголбанкнаас дараах бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгалаа. Үүнд:

- 1) Бизнесийн мөчлөгийн холимог бодлогыг баримтлах;
- 2) Эрсдэлд суурилсан, ирээдүйд чиглэсэн хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимтэй нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх, хэрэгжүүлэх;
- 3) Гадаад улсын санхүүгийн байгууллагаас Монгол улсад салбар, охин компани байгуулахад зөвшөөрөл олгох эсэх асуудлыг үндэсний эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлөх эсэхийг харгалзан үзэж олгох;
- 4) Хяналт шалгалтын газраас санхүүгийн салбарт оролцогч талууд, сонирхлын бүлгүүдтэй оновчтой харилцаа тогтоох, хамтын ажиллагааг дэмжиж ажиллах. Банк санхүүгийн үйлчилгээг харилцагчдад жигд хүртээмжтэй болгох, тэдний санхүүгийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авах.
- 5) Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын оновчтой хувилбарыг тусгай ажлын даалгавар, төлөвлөгөөний дагуу олон улсын санхүүгийн байгууллагуудын техник тусламжаар хэрэгжүүлэх.
- 6) Хяналт шалгалтын газрын боловсон хүчний талаарх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;
- 7) Гадаад улсын болон дотоодын бусад хянан шалгалтын эрх бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, өмнө нь тогтоосон ажлын харилцааг тодорхой чиглэлээр гүнзгийрүүлэх;
- 8) Базел II баримт бичгийн 2, 3 дугаар хэсгүүд болон шинэчлэн боловсруулсан Базел III стандартын холбогдох хэсгүүдийг одоо мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын хууль, журам, зааварт тусгаж мөрдүүлэх;
- 9) Банкуудын өөрийн хөрөнгийг дотооддоо үнэлэх болон удирдлагыг оновчтойгоор хийх чадварыг бэхжүүлэх;
- 10) Монголбанкнаас хяналт шалгалт, банкны эрсдэлийн хүрээнд аудитын байгууллагуудтай тогтоох хамтын ажиллагааг эрчимжүүлэх;
- 11) CAMELS болон бусад зэрэглэл тогтоох системийн үнэлгээг урьдчилан таамаглах эконометрик загварыг боловсруулж зайнаас тавих хяналт шалгалтад нэвтрүүлэн шийдвэр гаргалтад ашиглаж хэвших;
- 12) Монгол улсын бүртгэл мэдээллийн ажил эрхэлдэг эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, хамтран ажиллах;

- 13) Зээлийн мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх, мэдээллийн бүтцэд өөрчлөлт оруулах;
- 14) Зээлжих чадварын зэрэглэл (рейтинг) тогтоох дотоодын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах ажлыг хэрэгжүүлэх, одоогийн зохицуулалтын ажлын хүрээг боловсронгуй болгох;
- 15) Барьцаа хөрөнгийн үнэлгээг оновчтой хийх аргачлалыг боловсруулан банкуудад мөрдүүлэх, активын удирдлагын төрөлжсөн компанийг байгуулах боломжийг судалж хэрэгжүүлэх;
- 16) Олон улсын санхүүгийн зах зээл дээр бий болсон шинэ төрлийн бүтээгдэхүүнийг банкуудад нэвтрүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, хэрэгжүүлэх тохиолдолд гарч болзошгүй үр дагаврыг үнэлэх;
- 17) Монголбанкнаас хэрэгжүүлэх микро болон макро зохистой бодлого болон бусад макро бодлогуудын уялдаа холбоог хангах;
- 18) Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт болон банкны бүртгэлтэй холбоотойгоор бий болох зөрчлүүдийг шийдвэрлэж оновчтойгоор хэрэгжүүлэх;
- 19) Санхүүгийн тогтвортой байдлын тайланг хөрөнгө оруулагчдад өгөх мэдээллийн дохио хэлбэрээр ашиглах бодлогын хэрэгсэл болгох;
- 20) Хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог оновчтой нэвтрүүлэхэд Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран ажиллах.